

БАЛЧИРХАН УЛСЫН ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

Нэг. БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХ

Улаанбаатар хотын “Хүүхдийн цэцэрлэгүүдийн хүнсний төвлөрсөн хангамжийн төв” нь анх 1963 онд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд улс орны хөгжил, хүн амын өсөлтөөс хамаарч цэцэрлэгүүд олноор нэмэгдэн хотын хэмжээнд нэгдсэн нэг хангамжийн газар үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй болсноор 1980 онд дүүргүүдэд “Нэгдсэн хангамжийн газар”-ыг байгуулсан байна.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед дүүргүүдийн цэцэрлэгийн хангамжийн байгууллагууд хэрэгцээт хүнсний материалуудаа албан газарт үйлчлэх дэлгүүрээр дамжуулан авч цэцэрлэгүүдэд тарааж байсан ба хүнсний барааны тээвэрлэлтийг явуулахад дуудлагаар машин авч хэрэглэн гарч буй зардлуудыг улсын нэгдсэн төсвөөс төлж байжээ.

Найрамдлын районы АДХГЗ-ны 1992 оны 07 сарын 16-ны өдрийн 124 дүгээр тогтоолоор улс орон төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн харилцаанаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үед улсын хэмжээний төвлөрсөн хангамжийн газрууд задран улсын цэцэрлэгүүдийн хүнсний хангамж эрс муудаж хүнсний хомсдол үүсч ирсэн учир цэцэрлэгүүдийн хүнсний хангамжийг хариуцсан “Багачууд” компанийг байгуулсан байна.

Тус байгууллага нь анх байгуулагдахдаа складын үлдэгдэл болон тухайн үед хэрэглэж байсан үндсэн хөрөнгийг үнэлэн банкнаас зээл авч, улсын төсөвт буцаан төлж улмаар зээлийн хөрөнгөөр эргэлтийн хөрөнгө хийж үйл ажиллагаагаа явуулж байжээ. Тухайн үед улс орон нэг ёсондоо хүнсний болон мөнгөний хомсдолд орж байсан учир компани эргэлтийн хөрөнгөтэй болоход хүндрэлтэйг харгалзан үзэж Хятадын арьс ширний компанитай арьс шир нийлүүлэхээр гэрээ байгуулан урьдчилгаа зээл авч эргэлтийн хөрөнгөтэй болсон байна. Улмаар Хятад улсаас шар будаа, цагаан будаа, элсэн чихэр, Оросын холбооны улсаас гурил, масло, хатаасан жимс, цай, хөдөө орон нутгаас мах, сүү, цагаан идээ зэргийг бэлтгэн цэцэрлэгүүдэд нийлүүлэн хэвийн үйл ажиллагааг хангаж байжээ. “Багачууд” компани нь орон тооны хуьд дарга, ня-бо, нярав, жолооч, ачигч, сахиул, үйлчлэгч гэсэн 7 орон тоотойгоор Баянзүрх дүүргийн 24 цэцэрлэгт сурч хүмүүжиж буй 5000 орчим хүүхдийн бие бялдарын болон оюуны хөгжилд онцгой үүрэг гүйцэтгэхүйц эрүүл ахуйн шаардлага бүрэн хангасан илчлэг ихтэй тэжээллэг амин дэмээр баялаг хоол хүнсээр тасралтгүй хангах үйл ажиллагаа явуулж иржээ. Өнгөрсөн хугацаанд “Балчирхан” Улсын үйлдвэрийн газрын давуу тал нь:

- Байршлын хувьд цэцэрлэгүүдийнхээ дунд бүгдтэй нь утсан холбоогоор харилцах боломжтой
- Төв зам, автобусны буудлын ойролцоо учир биеэр уулзах шаарлагатай хүмүүст чирэгдэл багатай
- Сүүлийн 10 гаруй жил хүүхдүүдийн дунд хүнснээс болж нийтийг хамарсан өвчлөл гарч байгаагүй
- Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын Хорооны Мэргэжлийн хяналтын байгууллагуудаас шалгасан удаа дараагийн шалгалтаар үйл ажиллагаа нь бүрэн хэвшсэн гэсэн үнэлгээ авч байсан
- Сүүлийн 20-иод жилд байгалийн болон малын гоц халдварт өвчин гарч байгаагүй ган зудад нэрвэгдээд байдаггүй малаа эрүүлжүүлэх талаар мал эмнэлгийн байгууллага нь тогтмол сайн ажилладаг Архангай аймгийн Цахир сумыг сонгон байгалийн болон мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүнээ байнга авч хэвшсэн
- Хэрэглэж буй хүнсний бүтээгдэхүүнийг давхар шинжилгээ хийлгэж цэцэрлэгүүдэд хүргэж өгдөг
- Зориулалтын тээврийн хэрэгслээр цэцэрлэгүүдэд хүнсний барааг хүргэдэг ба хүнсний зүйлийг баталгаажуулсан жингээр жигнэн цэцэрлэгүүдэд өгдөг
- Татвар, нийгмийн даатгалд өр, авлагагүй дүүргийн татварын албанаас 2003, 2004 онд татварын хуулинд заасан үүргээ бүрэн хангалттай биелүүлсэн гэж А зэрэглэлийн гэрчилгээ авсан
- Хүнсний зүйлийг хадгалах склад, сав сайтай ба хурдан муудах зүйлийг хадгалах хөргөлтийн газартай тогтмол гэрээтэйгээр ажилладаг байсан

Тэр үед цэцэрлэгүүдэд нийлүүлсэн хүнсний материалын үнэ 1-2 сар хоцорч орохын сацуу зарим тохиолдолд 6 сараар хоцорч байсан байна. Улс орны эдийн засгийн байдал 1996 оноос тогтвортой шинж төлөв рүү орох үест цэцэрлэгүүдийн санхүүжилт 15 хоногоос 1 сараар хоцорч орж ирдэг болсон нь компанийн эргэлтийн хөрөнгөнд нөлөөлж эхэлсэн ба угийн эргэлтийн хөрөнгө муутай аж ахуй хурдан хугацаанд эдийн засгийн хувьд бүрэн бэхжиж чадахгүй байгааг харгалзан “Балчирхан” Улсын үйлдвэрийн газрыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2005 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 124 дүгээр тогтоолоор татан буулгасан байна.

Хоёр. ХӨМРӨГИЙН БАРИМТЫН ТҮҮХ

Улаанбаатар хотын Найрамдлын районы Багачууд компани, Балчирхан Улсын үйлдвэрийн газар нь Төрийн архивт хөмрөг үүсгэж байсан бөгөөд үйл ажиллагааны баримт бичгийг 2005 онд Нийслэлийн Архивын газарт ирүүлсэн байна. Архивч, сэлбэн засагч Ш.Гантуяа нь энэ байгууллагын баримтуудыг хүлээн авч 2005 онд ЭШТБ-ын ажлыг хийж гүйцэтгэн 1992-2004 оны байнга хадгалах 6ХН-ийн данс бүртгэл үйлдэн төрийн архивт хөмрөг үүсгэсэн байна.

Архивч-сэлбэн засагч Ё.Оюунцэцэг нь Төрийн архивт хадгалагдаж буй Найрамдлын районы Багачууд компани, Балчирхан Улсын үйлдвэрийн газрын байнга хадгалагдах баримтад 2012 оны 04 дүгээр сарын 20-ноос 2012 оны 04 дүгээр сарын 24-ний хооронд иж бүрэн дахин боловсруулалтын ажлыг хийж гүйцэтгэлээ. Баримтын бүрдлийн хувьд даргын тушаал, ирсэн бичиг, санхүүгийн тайлан тэнцэл зэрэг баримтуудаас бүрдэж хурлын тэмдэглэл, ажлын төлөвлөгөө тайлан, төсөв гэх мэтчилэн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой баримтын бүрдэл их дутуу байв.

Дахин боловсруулалтын ажил хийх явцад:

1. Найрамдлын районы “Багачууд” компани, “Балчирхан” Улсын үйлдвэрийн газрын 2005 онд үйлдсэн байнга хадгалагдах хадгаламжийн нэгжийн бүртгэлийн №2-т бүртгэгдсэн 1992-1996 оны 1ХН болгон авсан санхүүгийн тайлан тэнцлийг задалж байнга хадгалагдах шаадлагатай 1992-1996 оны 5ХН болгон оны дараалалд оруулж хуудас дугаарлах, үдэх, хавтаслах, нүүр тэмдэг дарах, нүүр бичилт хийх зэрэг техник боловсруулалтын ажлыг хийсэн. Мөн Найрамдлын районы “Багачууд” компани, “Балчирхан” Улсын үйлдвэрийн газрын 2005 онд үйлдсэн байнга хадгалагдах хадгаламжийн нэгжийн бүртгэлийн №6-д бүртгэгдсэн 1996-2004 оны 1ХН болгон авсан санхүүгийн тайлан тэнцлийг задалж байнга хадгалагдах 1996-2004 оны 8ХН болгон оны дараалалд оруулж хуудас дугаарлах, үдэх, хавтаслах, нүүр тэмдэг дарах, нүүр бичилт хийх зэрэг техник боловсруулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

2. Найрамдлын районы “Багачууд” компани, “Балчирхан” Улсын үйлдвэрийн газрын 2005 онд үйлдсэн байнга хадгалагдах хадгаламжийн нэгжийн бүртгэлийн №1-д бүртгэгдсэн 1992 оны захирлын тушаалд ирсэн бичгийг хамтад нь 1ХН болгон авсан байсныг салгаж байнга хадгалагдах шаардлагатай гэж үзсэн ирсэн бичгийг 1ХН болгон авч хуудас дугаарлах, үдэх, хавтаслах, нүүр тэмдэг дарах, нүүр бичилт хийх зэрэг техник боловсруулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

3. 2005 онд ЭШТБ хийгдсэн 1992-2004 оны байнга хадгалагдах 6 ХН-ийн нүүр бичилт хийгдээгүй байсныг нүүр бичилт хийж ХН-ийн дугаарыг нь зассан.

4. Сэлбэн засах, шинэчлэх шаардлагатай ХН-ийн хуудас урагдалтыг нөхөх техник боловсруулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

5. Баримтын дансны шилжүүлэх хүснэгт үйлдсэн.

Дахин боловсруулалтын ажлын үр дүнд: Цаашид эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй гэж үзсэн 2 нэр төрлийн 7ХН-ийг 1998-2004 оны 1, 2, 3 дугаар улирлын санхүүгийн тайлан тэнцлийг /ҮЖ-126в-ийн 5 жил/ устгахаар устгах хэргийн акт,

Байнга хадгалах 1992-2004 оны 19 хадгаламжийн нэгж бүхий данс бүртгэлийг 2012 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр шинэчилж үйлдэв.